

УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ ХХК

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хяналтад авсан арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээний арга зүй.

Монгол Улсын Засгийн газрын Албан даалгаврын түүвэр нэмэлт заалтуудаас байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай шийдвэр, зүйл заалтыг хяналтад авч, тэдгээрийн 2025 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийв. Хяналт-шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3 дугаар заалтыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын Албан даалгаврын түүвэр нэмэлт заалтуудад 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ хийхэд:

Хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ/гүйцэтгэл		Нийт
Хяналтад авсан арга хэмжээний тоо		2
1	Хэрэгжсэн	2
2	Хэрэгжээгүй	-
3	Хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж хувь		100%

“Хяналт-шинжилгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу хийхэд хяналтад авсан 2 заалт **100%**-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн гэж дүгнэв.

Хэрэгжилтийг холбогдох журмын дагуу үр дүнг тооцвол:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хэрэгжсэн заалтын тоо}}{\text{Нийт заалт тоо-Хугацаа болоогүй заалт}} * 100\% = \frac{2}{2-0} * 100\% = 100\% \text{ болно.}$$

Дөрөв. Дүгнэлт.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт нь тус онд төлөвлөсөн зорилтод бүрэн хүрч **100%** хангасан гэж дүгнэв.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА САНХҮҮГИЙН

ГАЗРЫН ДАРГА
ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ, ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Т.ЭНХМАА